



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ЗУСЛАНГ ХУВЬЧИЛСАН ШИЙДВЭРҮҮД ХУУЛЬ
ТОГТООМЖИД НИЙЦСЭН ХЭДИЙ Ч ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ
ДҮГНЭЖ, ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭСЭХ НЬ НОТЛОГДОХГҮЙ
БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: "ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ" СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН
АУДИТЫН КОД: УВА-2023/29-НА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батсайхан

Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453799, Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор Т.Золоо

Утас: 70453799, Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2023 он

Агуулга:

Товчилсон үгсийн жагсаалт.....	3
Аудит хийх үндэслэл:.....	4
Аудитын зорилт:.....	4
Аудитын хамрах хүрээ:.....	4
Аудитын арга зүй:.....	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:.....	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:.....	5
Ерөнхий мэдээлэл:.....	5
БҮЛЭГ 1. Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.....	6
1.1. "Хархираа" хүүхдийн зусланг хувьчлахдаа хуульд заасан арга хэлбэрийг сонгосон байна.....	6
1.2. "Хархираа" хүүхдийн зуслангийн өмч хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтоосон байна.....	6
1.3. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.....	7
БҮЛЭГ 2. Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн хүрээнд явагдсан хэдий ч орлогыг төвлөрүүлсэн эсэх нь нотлогдохгүй байна.....	8
2.1. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	8
2.2. Зарим баримт материал байхгүйгээс зах зээлийн үнэлгээг хэрхэн тооцож, орлогыг төвлөрүүлсэн эсэхийг нотлох боломжгүй байна.....	9
БҮЛЭГ 3. Гэрээний биелэлтийг дүгнэсэн танилцуулгыг баталгаажуулаагүй байна.....	10
3.1. Хувьчилсан шийдвэр, гэрээгээр хүлээсэн үүргээ оролцогч талууд зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.....	10-11
3.2. Гэрээний биелэлтийг дүгнэсэн танилцуулгыг баталгаажуулаагүй байна.....	12
ДҮГНЭЛТ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/02 дугаар тушаалаар баталж, А/67 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх.
- Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх.
- Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцсон эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Увс аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Архивын тасаг, хүүхдийн зуслангийн хувьчлалын асуудалд хамаарах төрийн байгууллага, албан тушаалтан, холбогдох шийдвэр, архивын баримт, материалыг авч аудитад хамруулсан.

Мөн “Хархираа” хүүхдийн зуслангийн хувьчлалтай холбоотой шийдвэр, гэрээний оролцогч талуудын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв.

Аудитын арга зүй:

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

Аудитаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг судлах, шалгадагч болон хамрагдагч байгууллагаас лавлагаа, тайлбар авах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотлох зүйлс цуглуулж, үр дүнг нягтлан шалгаж, аудитын дүн, дүгнэлтийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- БНМАУ-ын Өмч хувьчлах тухай хууль 1991 он
- Монгол Улсын Их Хурлын 2002 оны “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай” 56 дугаар тогтоол
- Монгол Улсын Их Хурлын 1995 оны “Өмч хувьчлалын тухай” 11 дүгээр тогтоол

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батсайхан, аудитор Ч.Мөнхтогтох, Т.Золоо нар хариуцан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсад анхны хүүхдийн зуслан 1926 онд үйл ажиллагаагаа эхлүүлж 1970-1990 оны хооронд “Бүхнийг хүүхдийн төлөө” гэсэн уриан дор нэгдэл, сангийн аж ахуй, үйлдвэр, албан байгууллагууд хүүхдийн зуслан олноор байгуулж байсан бөгөөд урьдчилсан байдлаар төрийн өмчит хүүхдийн зуслангийн чиглэлээр ажиллаж байсан 20 гаруй байгууллагыг хувьчилсан талаар баримт мэдээлэл байна.

“Хархираа” хүүхдийн зуслан 1955 онд Улаангомоос баруун хойш 30 км-т Хархираа уулын Мухар улиастайн аманд байгуулагдсан. Тухайн үед нэг ээлжид 200, нийтдээ 6 ээлжид 1200 хүүхэд хүлээн авч амраах хүчин чадалтай ажиллаж байжээ.

1992 оноос Хүүхдийн төлөө төвийн мэдэлд шилжин үйл ажиллагаагаа явуулж, 1998 оноос ОХУ-ын Тува улстай гэрээ байгуулан жилдээ 30-аас доошгүй хүүхэд хүлээн авч амрааж байсан байна.

“Хархираа” хүүхдийн зуслан 2003 онд 3.8 сая төгрөгийн өртөгтэй хүүхдийн амралтын зориулалтай 13 объект, гал тогоо, халуун ус, 2 айлын орон сууц, багш нарын сууц гэсэн нийт 19 барилга, 3.3 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байжээ.

Увс аймгийн ИТХ-ын 2003 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “Хархираа” хүүхдийн зусланг хувьчилсан байна.

“Хархираа” хүүхдийн зуслан нь өнөөдрийг хүртэл үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчлөхгүйгээр жилд дунджаар 250 хүүхэд хүлээн авч хэвийн үйл ажиллагаатай ажиллаж байна.

БҮЛЭГ 1. Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

1.1. “Хархираа” хүүхдийн зусланг хувьчлахдаа хуульд заасан арга хэлбэрийг сонгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан байна.

Мөн хуулийн 6 дугаар бүлгийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дараах аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ” гэж заажээ. Үүнд:

1. Дуудлагаар худалдах;
2. Уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/ ;
3. Төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах;
4. Төрийн өмчит хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах;
5. Татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах;
6. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах;
7. Давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах.
8. Төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хувьчлах.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2003 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоолоор уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/ аргыг сонгож “Хархираа” хүүхдийн зусланг хувьчлах шийдвэр гаргасан байна.

1.2. “Хархираа” хүүхдийн зусланг хувьчлахаас өмнө хөрөнгийн худалдах доод үнийг тогтоосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтооно” гэж заажээ.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 30 дугаар тогтоолоор “Увс аймгийн “Хархираа” хүүхдийн зусланг нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлах тендерийн төсөл шалгаруулах журам”-ыг баталсан байна.

Дээрх журмын 1-д “аймгийн орон нутгийн өмчийн зөвлөл /цаашид зөвлөл гэнэ/ энэ ажлыг зохион байгуулж явуулна” гэж заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн албаны 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Хархираа” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулж, барилга байшин 3.1 сая, тоног төхөөрөмж 0.6 сая, аж ахуйн материал 3.3 сая, нийт 7.1 сая төгрөгөөр доод үнийг тогтоосон талаар аймгийн Засаг даргын 2003 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн зөвлөлийн хурлын тэмдэглэлд дурдсан байна.

“Хархираа” хүүхдийн зуслангийн өмч хөрөнгийн худалдах доод үнийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хөрөнгийн ангилал	Үнэ
1	Барилга байшин	3148560.0
2	Тоног төхөөрөмж	637400.0
3	Аж ахуйн материал	3270724.0
	Дүн	7056684.0



1.3. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”-ийн 1.5-д “... нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийхэд дараах төрийн өмчийн байгууллага, тусламж, үйлчилгээ хамрагдана”, 1.5.3-д “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт”, 1.5.3.3-д “Хүүхдийн ордон, зуслан” гэж тусгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй”, 77.2.3¹-д заасны дагуу Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Увс аймагт 2003 онд хувьчлах, бүтцийн өөрчлөлт хийх байгууллага, объектын жагсаалтыг баталжээ. Уг жагсаалтад “Хархираа” хүүхдийн зусланг оруулж баталсан байна.

Дээрх үндсэн чиглэл, төрийн өмчийн хорооны санал зөвлөмж, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн

¹ орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө.

2003 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “Хархираа” хүүхдийн зусланг 8 146 000 /найман сая нэг зуун дөчин зургаан мянга/ төгрөгөөр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах шийдвэрийг гаргасан байна.

БҮЛЭГ 2. Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа нь хууль, тогтоомжийн хүрээнд явагдсан хэдий ч орлогыг төвлөрүүлсэн эсэх нь нотлогдохгүй байна.

2.1. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д “Хувьчлах тухай зар, мэдээнд дараах зүйлийг заавал тусгана” гэж заажээ. Үүнд:

1. Хувьчлагдах хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эдэлбэр газрын хэмжээ, шинж чанар, хэрэв түүнийг түрээслэн авсан бол түүний нөхцөл, төлбөрийн тооцоо;
2. Нийт хөрөнгийн нэр төрөл, үнэ, өр, авлагыг бүрэн тусгасан тухайн жил, улирлын тайлан, тэнцэл, эдийн засгийн үр ашгийн болон төлбөрийн чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд;
3. Эрхэлдэг ажил, үйлчилгээний нэр төрөл;
4. Хувьчлах эд хөрөнгийн санал болгосон доод үнэ;

“Хархираа” хүүхдийн зусланг нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлах тендерийн зар мэдээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна 47 дугаар зүйлийн 47.2² дахь хэсэгт заасныг тусгаж сонинд нийтлүүлэх замаар нийтэд мэдээлсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 30 дугаар тогтоолоор “Хархираа” хүүхдийн зусланг нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлах тендерийн төсөл шалгаруулах журмыг баталсан байна. Уг журамд тендер шалгаруулалтын ажлыг аймгийн Орон нутгийн өмчийн алба зохион байгуулж явуулахаар тусгажээ.

Уралдаант шалгаруулалтад иргэн Л.Мөнхбаяр, М.Мягмаржав нар төсөл ирүүлснийг аймгийн Орон нутгийн өмчийн алба /шинжээчдийн баг/ тендерийн төсөл шалгаруулах журам, тендерийн бичиг баримтад тусгагдсан шаардлагыг баримтлан үнэлэхэд иргэн Л.Мөнхбаяр үнийн санал 10.0 сая, хөрөнгө оруулалтын санал ирүүлээгүй, иргэн М.Мягмаржав үнийн саналыг 8.5 сая, хөрөнгө оруулалтын саналыг 22.0 сая төгрөгөөр тус тус ирүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн алба /шинжээчдийн баг/ ирүүлсэн төслийг 5 үзүүлэлтээр дүгнэж иргэн Л.Мөнхбаярын төсөлд нийт 137 оноо дундаж 27.4, иргэн М.Мягмаржав-д нийт 141 оноо дундаж 28.2 оноо өгч иргэн М.Мягмаржавын төслийг шалгаруулсан талаар “Хархираа” хүүхдийн зусланг хувьчлах тендер шалгаруулах ажлын хэсгийн 2003 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн шалгаруулалтын хурлын тэмдэглэл,

²1/ хувьчлагдах эд хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих нэмэлт болзол, шаардлага;

2/ төсөл шалгаруулах үндсэн үзүүлэлтүүд;

3/ шалгаруулалтад оролцогчдыг урьдчилан бүртгэх хугацаа;

4/төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх эцсийн хугацаа;

аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан байна.

2.2. Зарим баримт материал байхгүйгээс зах зээлийн үнэлгээг хэрхэн тооцож, орлогыг төвлөрүүлсэн эсэхийг нотлох боломжгүй байна.


Аудитын хүрээнд “Хархираа” хүүхдийн зуслангийн хувьчлалын талаарх баримт материал авахаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ЗДТГ-ын Төрийн архивын тасаг, Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр хандсан боловч зах зээлийн үнэлээг тогтоосон болон орлого төвлөрүүлсэн баримт байхгүй байна.

Дээрх баримт материалын талаар ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ирүүлсэн 7/1752 дугаар албан бичигт “Санхүүгийн баримт архивд хадгалах хугацаа 15 жил бөгөөд 2003 оны “Хархираа” хүүхдийн зуслангийн нээлттэй уралдаан шалгаруулалтаар хувьчлах шийдвэрийн дагуу 8.1 сая төгрөг төвлөрүүлсэн баримт архивд байхгүй байна” гэжээ. Мөн тухайн үед “Хархираа” хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэн М.Мягмаржав нь нас барсан зэргээс шалтгаалан орлогыг төвлөрүүлсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

БҮЛЭГ 3. Гэрээний биелэлтийг дүгнэсэн танилцуулгыг баталгаажуулаагүй байна.

3.1. Хувьчилсан шийдвэр, гэрээгээр хүлээсэн үүргээ оролцогч талууд зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт "Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй", 77.2.3³ дахь заалтад заасны дагуу Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар "Орон нутгийн өмчийн байгууллага, үл хөдлөх хөрөнгө хувьчлах тухай" тогтоолоор "Хархираа" хүүхдийн зусланг хувьчлахаар шийдвэрлэж байжээ.



Түүнчлэн Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 48 дугаартай "Үнэлгээний тайлан батлах тухай" тогтоолын 1-д "...Хархираа хүүхдийн зусланг хувьчлах тендер шалгаруулах шинжээчдийн ажлын хэсгийн, тендерт оролцогч 06231758 кодтой иргэн М.Мягмаржавыг ялагчаар шалгаруулсан үнэлгээний тайланг баталсугай", 2-т "Хархираа хүүхдийн зусланг нээлттэй уралдаант шалгаруулалтаар хувьчлах тендерт шалгарсан иргэн М.Мягмаржавтай үйл ажиллагааны гэрээ байгуулан, гарын үсэг зурж баталгаажуулахыг аймгийн Засаг даргад/-д зөвшөөрсүгэй" гэсэн шийдвэр гарч байжээ.

Дээрх шийдвэрийн дагуу аймгийн Орон нутгийн өмчийн алба иргэн М.Мягмаржавтай "Хархираа" хүүхдийн зусланг худалдах, худалдан авах" гэрээг байгуулж, аймгийн Засаг даргаар батлуулж байсан байна. Уг гэрээний 1-д нийтлэг үндэслэл, гэрээний хугацаа, талуудын нэр, хууль ёсны хаяг, бизнес төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тусгасан байна.

³ орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө.

Мөн гэрээний 2-д "Үүрэг гүйцэтгүүлэгч нь орон нутгийн мэдлийн өмч болох "Хархираа" хүүхдийн зуслангийн өмчийг хувьчлах төсөл сонгон шалгаруулалтын ялагчид гэрээний үндсэн дээр шилжүүлж, үүрэг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад ялсан төсөл /тендерийн санал/-ыг гэрээнд заасан хугацаа, нөхцлийн дагуу хэрэгжүүлэх боломжоор хангах, гэрээний хугацаа дуусмагц гэрээ дүгнэсний үндсэн дээр Хархираагийн хүүхдийн зусланг хувьчлалын асуудлыг шийдвэрлэхэд оршино", 3-д гэрээний нөхцөл хэсэгт "дуудах үнийн 20 хувьтай тэнцэх хэмжээний дэнчин, хөрөнгийн өмчлөл, гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх харилцааг, 4-д "үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх, үүргийг", 5-д "үүрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг", 6-д "гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах буюу цуцлах", 7-д "гэрээг дүгнэх, дуусгавар болгох тухай", 8-д бусад зүйл хэсэгт талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх, гэрээг хэдэн хувь үйлдэх талаар тусгасан байна.

Гэрээнд тусгагдсан талуудын үүргийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1

Гэрээний заалтын дугаар	Дөрөв. Үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг	Гэрээний заалтын дугаар	Тав. Үүрэг гүйцэтгэгчийн үүрэг
4.1	Үүрэг гүйцэтгүүлэгч нь "Хархираа" хүүхдийн зуслангийн эд хөрөнгө ба эд хөрөнгийн эрхийг энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш 14 хоногт багтаан үүрэг гүйцэтгэгчид шилжүүлж, энэхүү гэрээний хавсралтад заасан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх бололцоогоор хангана.	5.3	Гэрээний хугацаанд Хархираа хүүхдийн зуслангийн эд хөрөнгөд хөдөлгөөн хийх /эд хөрөнгө худалдах актлах, шилжүүлэх, барьцаалах, түрээслэх, орон тоо цомхотгох гэх мэт/ асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэхүү гэрээнд зааснаар шийдвэрлэнэ.
4.2	Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш нэг сарын дотор гэрээний биелэлт, Хархираагийн хүүхдийн зуслангийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдал, ашиглалт, үйлдвэрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд шалгалт хийж, дүгнэлт гаргах эрх бүхий ажлын хэсгийг томилно.	5.4	Үүрэг гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд Хархираагийн хүүхдийн зуслангийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй.
		5.5	Үүрэг гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөнөөс орон нутгийн өмчид учруулсан хохирол нь барьцаалсан хөрөнгөөс илүү гарсан тохиолдолд хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

Дээрх хүснэгтийн 4.1-д тусгагдсан үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын 2003 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 184 дүгээр захирамжаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн 2003 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Хархираа хүүхдийн зуслан дээр ажиллаж тендерт шалгарсан иргэн М.Мягмаржавт хөрөнгө хүлээлгэн өгч акт үйлдсэн, 4.2-д тусгагдсан үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын 2003 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 230 дугаар захирамжаар "Хархираа хүүхдийн зуслангийн тендерийн ялагчийн үйл ажиллагаанд хяналт тавих" ажлын хэсгийг байгуулсан нь үүрэг гүйцэтгүүлэгч тал гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэн ажилласныг харуулж байна.



3.2. Гэрээний биелэлтийг дүгнэсэн танилцуулгыг баталгаажуулаагүй байна.

Увс аймгийн “Хархираа” хүүхдийн зусланг худалдах худалдан авах гэрээний 1.2-д “Гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү гэрээ 1 жилийн хугацаанд хүчинтэй байна”, 2.1-д “... гэрээний хугацаа дуусмагц гэрээ дүгнэсний үндсэн дээр Хархираагийн хүүхдийн зусланг хувьчлалын асуудлыг шийдвэрлэхэд оршино”, 7.1-д “Гэрээний хугацаа дуусгахад талууд гэрээг дүгнэснээр гэрээ дуусгавар болно. Гэрээг журамд заасан шалгуур үзүүлэлт, тендерийн санал дүгнэх үзүүлэлтээр дүгнэнэ” гэж заажээ.

Аймгийн Засаг даргын 2003 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 230 дугаар захирамжаар “Хархираа хүүхдийн зуслангийн тендерийн ялагчийн үйл ажиллагаанд хяналт тавих” ажлын хэсгийг байгуулсан шийдвэр гарсан хэдий ч хяналтыг хэрэгжүүлсэн талаарх баримт материал байхгүй байна.

Мөн аймгийн Засаг даргын 2004 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 341 дүгээр захирамжаар гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсгийг томилжээ. Уг ажлын хэсэг нь гэрээг дүгнэсэн тухай танилцуулгаа гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Тухайн үед ажлын хэсгийн ахлагчаар томилогдож байсан стратегийн төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн ажилтан /тухайн үеийн албан тушаал/ Р.Дэлгэрмаагаас тодруулахад “... би тэр үед гэрээг дүгнэх ажлаар Хархираа зуслангийн үйл ажиллагаатай танилцаагүй болно” гэсэн тайлбарыг өглөө.

Ажлын хэсгийн баримтыг хавсаргав.

Хархираа хүүхдийн зусланг Худалдах худалдан авах гэрээг дүгнэсэн тухай танилцуулга	10 Хоолны орлогын нормыг Мэргэжлийн хяналтын газрын үйлсэн байрлалаар хянуулж, батлуулж, мөрдөж ажилласаа 11 Амрагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөөр хамгийн бүртгүүлж зорилгоор төмөрний шарз, бэлгэдсэн шашаа шийдэл сүүрүүлж, шашаа, нөсөөлсөн талбайг шалгалж зурж ажлуулж байгаа
2004.08.23 Улаанбаатар	
Гэрээг аймгийн Засаг даргын 2004 оны 341 тоот захирамжаар томилогдон ажлын хэсгийн ахлагч ЗДТГ-ын ажилтан Р.Дэлгэрмаа, ажлын хэсгийн гишүүн аймгийн орон нутгийн өмчийн төлөөлөгч Л.Батмаа нар дүгнэж Ажлын хэсгийн гишүүн ЗДТГ-ын ажилтан Б.Алтанхүүд тэг цаглаантай үнэмлэхүйгээр	Ажлын хэсэг Хархираа хүүхдийн зусланг худалдах худалдан авах гэрээг худалдан авчигч Бизнес төлөөлөгчөөр хэрэгжилтгүй дүгнэж үүрэг гүйцэтгэгч М.Менгэрмаа гэрээний биелэлтийг хянаж ажилласан гэж үзсэн
Гэрээг дүгнэх үүрэг:	
1. Хархираа хүүхдийн зуслангийн үндсэн хөрөнгийг барилда, байгууламж бүрэн бүтэн байгаа 2. Зүслэнгийн Сансар бүтэйд 4 байрны урсгал зохиор хийж, амрагчдын аж тух байрны өнгө үзэмжийг сайжруулжээ 3. Жилийн барын шавилгаан үүргүүр ажиллуулж зарим хүнэд зохих хяналттай хяналжээ 4. Туслах аж ахуй мөрдүүлж 100 хонь, 8 хортон бэлх, үлдсэн хоньныг хяналдаж, төмс, хүнсний ногоо тариалж, сүү, мах, хүнсний ногооны хяналттай хяналж ажилласаа 5. Сүүнийг 2 жилд жилдээ 7 эхнээр өөрийн аймгийн болон зорилгоор Холд аймгад ОХУ-ын Тууш улсын 550-680 хүүхэд багачуудыг хүлээн авч амруулжээ 6. 1 хүүхэд амруулж хоньныг хяналж 2000 Т-нээс хяналттай байн 7. Хүүхдийн зусланд амрагчдын өдрийн хоолны дэвдээ 7 хоньгоор урьдчилан гаргаж, адарт 5 урмалын хоол зүүжээр үйлчилж ажилласаа 8. Хүүхдийн зуслангийн эрүүл ахуйн шаардлагыг хангах тулд амрагчид ажлаж, үрд Мэргэжлийн ажилтангаар шалгуулж, оруулган, устгал хяналтуулж хүүхэд амраа бүх зогшино нарийн мэргэжлийн зоч ажиллуулсан байна 9. 100 хүүхдийн орны цагаан хэрэгсэл ажилласаа	Танилцуулга бүтсэн Ажлын хэсгийн ахлагч Р.Дэлгэрмаа Гишүүн Л.Батмаа
	

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.
2. Зарим баримт материал байхгүйгээс зах зээлийн үнэлгээг хэрхэн тооцож, орлогыг төвлөрүүлсэн эсэх нь нотлогдохгүй байна.
3. Гэрээний биелэлтийг дүгнэсэн танилцуулгыг баталгаажуулаагүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ
ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

С.Батсайхан
Ч.Мөнхтогтох
Т.Золоо

С.БАТСАЙХАН
Ч.МӨНХТОГТОХ
Т.ЗОЛОО